



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 21 өдөр

Дугаар А/316

Мандалговь

Аялал жуулчлалын "Наадам" эвент арга
хэмжээний зардал батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 60.1.21, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2, 16.1.8, 16.1.12, Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 27 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2022 оны төсвийн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтын 4.13 дахь хэсэгт батлагдсан "Аялал жуулчлалын "Наадам" эвент арга хэмжээ" ажлын батлагдсан зардлын задаргааг хавсралтаар баталсугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө, оруулалтын хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822111088